



МОНГОЛ УЛСЫН
ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙДЫН
ТУШААЛ

2022 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/152

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид шагнал олгох журам”-ын 2.4 дэх хэсэг, 2 дугаар хавсралтаар батлагдсан “Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан” хүндэт тэмдгийн төрөл, түүнийг олгох эрх бүхий албан тушаалтны 33, 45 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан хүндэт тэмдэг болон Эдийн засаг, хөгжлийн яамны шагнал олгох журам”-ыг нэгдүгээр, “Эдийн засгийн тэргүүний ажилтан”, “Худалдааны тэргүүний ажилтан” хүндэт тэмдгийн загварыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. “Эдийн засгийн тэргүүний ажилтан”, “Худалдааны тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг, дагалдах үнэмлэх, яамны жуух бичгийн зардлыг сайдын жил бүрийн төсвийн багцад тусгуулахыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга /Х.Отгонзул/ -д даалгасугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Б.Дашпүрэв/-т үүрэг болгосугай.

САЙД



Ч.ХҮРЭЛБААТАР



ЗАСГИЙН ГАЗРЫН САЛБАРЫН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН
ХҮНДЭТ ТЭМДЭГ БОЛОН ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМНЫ
ШАГНАЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн салбарт онцгой амжилт гаргасан, мэргэжлээрээ тогтвортой, үр бүтээлтэй ажилласан Монгол Улсын болон гадаад улсын иргэн /цаашид “нэр дэвшигч” гэх/-ийг яамны шагналд нэр дэвшүүлэх, тодорхойлох, шагнал олгохтой холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

Хоёр. Шагналын төрөл

2.1. Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан хүндэт тэмдэг, Эдийн засаг, хөгжлийн яамны шагнал нь дор дурдсан төрөлтэй байна. Үүнд:

- 2.1.1. “Эдийн засгийн тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг;
- 2.1.2. “Худалдааны тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг;
- 2.1.3. Эдийн засаг, хөгжлийн яамны “Жуух бичиг”.

Гурав. Шагнал олгох ерөнхий нөхцөл

3.1. Шагналыг яам, Засгийн газар гэсэн дарааллаар дор дурдсан шалгуур үзүүлэлтийг хангасан албан хаагч, иргэнд олгоно. Үүнд:

3.1.1 Эдийн засаг, хөгжлийн яамны “Жуух бичиг”-ээр тухайн салбартаа 5-аас доошгүй жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж, ажил үйлсээрээ хамт олноо манлайлсан ажилтан, албан хаагчдыг;

3.1.2. “Эдийн засгийн тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр санхүү, эдийн засгийн салбарт 15-аас доошгүй жил мэргэжлээрээ идэвх зүтгэл, үр бүтээлтэй, ажлын өндөр амжилт гарган ажилласан ажилтан, албан хаагч болон бусад;

3.1.3. “Худалдааны тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр гадаад, дотоод худалдааны салбарт 15-аас доошгүй жил ажилласан, дэвшилтэт техник, технологи, шинжлэх ухааны ололтыг үйлчилгээнд нэвтрүүлсэн ажилтан, албан хаагч болон бусад.

3.2. Тухайн салбарыг хөгжүүлэн бэхжүүлэх үйл хэрэгт болон эрхэлсэн ажилдаа онцгой амжилт, шинэ санаачилга, бүтээл гарган салбарын хөгжилд бодитой хувь нэмэр оруулсан ажилтан, албан хаагч, иргэнийг энэхүү журмын 3.1.1-3.1.3-т заасан хугацааг харгалзахгүйгээр шагнаж болно.

3.3. Монгол Улсын эдийн засгийг хөгжүүлэн бэхжүүлэх үйл хэрэгт онцгой амжилт гаргасан, санхүү эдийн засгийн бодитой дэмжлэг туслалцаа үзүүлсэн гадаадын иргэнийг шагнаж болно.

3.4. Шагналыг шатлан ахих журмаар олгох бөгөөд шагнагдсанаас хойш 3-аас доошгүй жил тогтвортой ажиллаж, ажлын амжилт, үр бүтээл нь өмнөх түвшнээс ахисан нөхцөлд дараагийн шатны шагналд нэр дэвшүүлж тодорхойлно.

3.5. Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан тэмдэг болон Эдийн засаг, хөгжлийн яамны шагналыг Эдийн засаг, хөгжлийн сайдын тушаалаар олгоно.

Дөрөв. Шагналд нэр дэвшүүлэх, түүнийг хүлээн авах

4.1. Төрийн албан хаагчийг тухайн байгууллагын удирдлага нэр дэвшүүлж, хамт олны хурлаар хэлэлцүүлэн, тодорхойлно.

4.2. Салбарын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан болон тухайн байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад ажилтныг одоо ажиллаж байгаа болон хамгийн сүүлд ажиллаж байсан байгууллага, аж ахуйн нэгж нь шагналд тодорхойлно.

4.3. Аль нэг байгууллага, аж ахуйн нэгжид харьяалалгүй ахмад болон хувиараа хөдөлмөр эрхэлдэг иргэн, ахмад настныг оршин сууж буй аймаг, дүүргийн Засаг дарга тодорхойлж болно.

4.4. Үндэсний хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод нь шагналд тодорхойлж болно.

4.5. Шагналд нэр дэвшигчийг тодорхойлохдоо дор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ.

4.5.1. Шагнуулахаар өргөн мэдүүлсэн үндсэн байгууллагын хүсэлт;

4.5.2. Шагналд нэр дэвшигчийн танилцуулга /маягт 1/;

4.5.3. Ажил байдлын тодорхойлолт;

4.5.4. Хамт олны хурлаар хэлэлцсэн тэмдэглэл;

4.5.5. Онцгой амжилт гаргасан бол түүнийг гэрчлэх баримт бичиг.

4.6. Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан тэмдэг болон Эдийн засаг, хөгжлийн яамны шагналаар шагнуулах хүсэлтээ Санхүү, эдийн засагчдын өдөр, Үндэсний их баяр наадам болон бусад тэмдэглэлт баяр болохоос 30-аас доошгүй хоногийн өмнө Эдийн засаг, хөгжлийн яаманд ирүүлнэ.

4.7. Шагналд нэр дэвшигчийн баримт бичгийн бүрдэл дутуу, хуурамч бичиг баримт ирүүлсэн, Эдийн засаг, хөгжлийн яамны шагнал олгох журамд заасан ерөнхий нөхцөлийг хангаагүй тохиолдолд холбогдох материалыг буцаан хүргүүлнэ.

4.8. Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн захиргааны удирдлагын газар шагнуулах тухай хүсэлт, тодорхойлолтыг хүлээн авах, түүнийг хянан нягтлах, шагнал олгох шийдвэр гаргуулах ажлыг эрхлэн гүйцэтгэнэ.

4.9. Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн захиргааны удирдлагын газар шагнагдсан ажилтны нэгдсэн бүртгэлийг хөтөлнө.

Тав. Засгийн газрын салбарын тэргүүний болон
Эдийн засаг, хөгжлийн яамны шагналын тэмдэг,
үнэмлэхийг нөхөн олгох

5.1 “Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг, үнэмлэх болон яамны “Жуух бичиг”-ийг үрэгдүүлсэн буюу гэмтээсэн тохиолдолд шагналын эзэн, түүний гэр бүлийн хамаарал бүхий этгээдэд нь зохих үнээр нөхөн болон сольж олгож болно.

5.2. Үнэмлэх, тэмдгийн шагналын эзэн эсхүл түүний гэр бүлийн хамаарал бүхий этгээд нөхөн болон сольж авахыг хүсвэл дараах баримтыг бүрдүүлэн Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн захиргааны удирдлагын газарт хүсэлтээ гаргана.

5.2.1. Тэмдэг, үнэмлэх нөхөн олгохыг хүссэн өргөдөл;

5.2.2. Иргэний үнэмлэхийн хуулбар;

5.2.3. Шагналын үнэмлэхийн хуулбар;

5.2.4. Үнэмлэхээ үрэгдүүлсэн бол шагнагдсан шийдвэрийн хуулбар;

5.2.5. Мөнгө тушаасан баримт;

5.3. Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн захиргааны удирдлагын газар өргөдлийг хүлээн авч хянан тэмдэг, үнэмлэхийг нөхөн олгох асуудлыг шийдвэрлэнэ.

---oooOooo---

**ЗАСГИЙН ГАЗРЫН САЛБАРЫН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН
ХҮНДЭТ ТЭМДЭГ БОЛОН ЭДИЙН ЗАСАГ ХӨГЖЛИЙН
ЯАМНЫ ШАГНАЛААР ШАГНУУЛАХААР
НЭР ДЭВШҮҮЛСЭН ХҮНИЙ ТАНИЛЦУУЛГА**

1. Ургийн овог:
2. Эцэг/эхийн нэр
3. Нэр:
4. Хүйс:
5. Регистрийн дугаар:
6. Төрсөн аймаг, сум, хот:
7. Одоогийн харьяалал:
8. Боловсрол:
9. Ажилладаг салбар:
10. Мэргэжил:
11. Урьд болон одоо эрхэлж байгаа ажил /хүснэгтэд бичнэ/:

№	Ажилласан байгууллага, аж ахуй нэгжийн нэр	Хугацаа /он, сар/	Эрхэлсэн ажил, албан тушаал
1.			
2.			
3.			
4.			

12. Улсад ажилласан жил:

Үүнээс: Тухайн салбарт ажилласан жил:

13. Урьд шагнагдаж байсан шагналууд: /Монгол Улсын цол, одон медаль, яамны "Жуух бичиг" болон бусад

№	Шагналын нэр	Хэдэн онд
1.		
2.		
3.		
4.		

14. Шагнуулах үндэслэл:

16. Ямар шагналаар шагнуулах хамт олны санал:


17. Хамт олны саналын хувь:

18. Байгууллагын холбоо барих ажилтны нэр, утасны дугаар:

..... байгууллагын даргын гарын үсэг

/тамга, тэмдэг/

Эдийн засаг, хөгжлийн сайдын
2022 оны 12 сарын 16 өдрийн
1/152 дугаар тушаалын 2-р хавсралт



**“ЭДИЙН ЗАСГИЙН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН”,
“ХУДАЛДААНЫ ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН”**

ХҮНДЭТ ТЭМДГИЙН ЗАГВАР



“Эдийн засгийн тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг нь гонзгой дугуй хэлбэртэй, эргэн тойрон ялалтыг бэлгэдсэн навчин хүрээтэй, уг хүрээнийхээ оройд төрийн соёмботой, хоёр захад нь улаан өнгийн шигтгээг байршуулсан, тэмдгийн гол хэсэгт Эдийн засгийн тэргүүний ажилтан гэж Монгол үсгээр бичсэн байна. Тэмдгийн урт нь 42 мм, өргөн нь 30 мм, зузаан нь 3 мм байна.



“Худалдааны тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг нь гонзгой дугуй хэлбэртэй, эргэн тойрон ялалтыг бэлгэдсэн навчин хүрээтэй, уг хүрээнийхээ оройд төрийн соёмботой, хоёр захад нь улаан өнгийн шигтгээг байршуулсан, тэмдгийн гол хэсэгт Худалдааны тэргүүний ажилтан гэж Монгол үсгээр бичсэн байна. Тэмдгийн урт нь 42 мм, өргөн нь 30 мм, зузаан нь 3 мм байна.